

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөний үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажилд оролцохыг урьж байна.

Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад оролцох байгууллага ажлын даалгаварын тавигдах шаардлагыг хангасан талаарх холбогдох материал, үнийн саналаа 2026 оны 04 дүгээр сарын 17-ний өдрийн 10⁰⁰ цагт цаасан хэлбэрээр ЦУОШГ-ын шинэ байрны 3 давхар 302 тоот ахлах мэргэжилтэн П.Тамирт ирүүлж хамтран ажиллахыг хүсье.

Дэлгэрэнгүй мэдээллийг 11-326611-ээс лавлана уу.

Ажлын хэсэг

Улаанбаатар хот

2026.02.26

БАТЛАВ.

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА

..... Э.БАТТУЛГА

2026 оны 2 дугаар сарын 26 -ны өдөр

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

1. Нийтлэг үндэслэл

Ус цаг уур, орчны хяналт, шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаатай холбогдуулан уг хуулийн төслийг баталж хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэх нийгэм, эдийн засаг, байгаль орчин, захиргаа, төсөв санхүүгийн үр нөлөөг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан аргачлалын дагуу үнэлэх шаардлага үүссэн. Иймд уг ажлыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг энэхүү баримт бичгээр тодорхойлж байна.

2. Зорилго

Ус цаг уур, орчны хяналт, шинжилгээний тухай хуулийн (цаашид "УЦУОХШТХ" гэх) шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан шаардлага, аргачлалын дагуу үнэлж, шийдвэр гаргагчдыг бодит мэдээллээр хангах.

3. Гүйцэтгэх ажлын хүрээ

Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

3.1 Үр нөлөөний үнэлгээ

- УЦУОХШТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан аргачлалын дагуу үнэлэх
- Хуулийн төслийн нийгэм, эдийн засаг, байгаль орчин, төсөв санхүү, захиргааны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох
- Хуулийн төслийн хэрэгжилтийн давуу болон сул тал, эрсдэл, боломжийг үнэлэх

3.2 Тайлан, дүн шинжилгээ

- Үр нөлөөний үнэлгээний дэлгэрэнгүй тайлан боловсруулах
- Үнэлгээний аргачлал, үндэслэл, хэрэглэсэн мэдээлэл, таамаглалыг тайлбарлах
- Хуулийн төслийг хэрэгжүүлэх үе шатны анхаарах асуудал, санал, зөвлөмж боловсруулах

3.3 Зөвлөлдөх, санал тусгах

- Ажлын хэсэг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ), Цаг уур, орчны шинжилгээний газар (ЦУОШГ)-ын холбогдох албан тушаалтнуудаас санал авч тусгах
- Шаардлагатай тохиолдолд танилцуулга, хэлэлцүүлэг зохион байгуулах
- Хуулийн төсөл батлагдах хүртэл шаардлагатай тодруулга, тайлбар, зөвлөмж гаргах

4. Гүйцэтгэх хугацаа

Гэрээ байгуулснаас хойш ажлын 15 хоногийн дотор ажлыг бүрэн гүйцэтгэж тайлагнана.

5. Ажил гүйцэтгэх байгууллагад тавих шаардлага

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1.3-т заасан аргачлалын дагуу үр нөлөөний үнэлгээ хийх чадавхтай байх
- 5-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай хуулийн этгээд байх
- 3-аас доошгүй орон тооны мэргэжлийн ажилтантай байх
- Хууль эрх зүй, бодлогын судалгаа, хуулийн төсөл боловсруулах чиглэлээр туршлагатай байх
- Ижил төстэй судалгаа, үр нөлөөний үнэлгээ хийж байсан туршлагатай байх
- Ажил гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөөг ирүүлэх
- Сонгогдсон тохиолдолд ажлыг хариуцсан үндсэн зөвлөхийг томилон ажиллуулах
- Захиалагч байгууллагуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, багаар ажиллах чадвартай байх

Бүрдүүлэх материал

- Байгууллагын танилцуулга
- Мэргэжилтнүүдийн товч танилцуулга
- Мэргэжлийн болон мэргэшлийн нотлох баримт
- Ижил төстэй гүйцэтгэсэн ажлын жагсаалт

6. Захиалагч байгууллага

- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
- Цаг уур, орчны шинжилгээний газар

7. Санхүүжилтийн эх үүсвэр

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох” төслийн санхүүжилтээр хэрэгжинэ.

8. Тайлагналт

Гүйцэтгэгч нь ажлын тайланг Хууль тогтоомжийн тухай хууль болон энэхүү ажлын даалгаварт нийцүүлэн боловсруулж:

- 2 хувь цаасан хэлбэрээр
- шаардлагатай тохиолдолд цахим хэлбэрээр захиалагч байгууллагад хүлээлгэн өгнө.

9. Санхүүжилт, төлбөрийн нөхцөл

Энэхүү зөвлөх үйлчилгээний нийт төсөв 17,925,000 (арван долоон сая есөн зуун хорин таван мянга) төгрөг байна. Үүнд ажлын хөлс, татвар, шимтгэл, холбогдох бүх зардал багтсан болно.

Гүйцэтгэгч нь тайлан, судалгааг бүрэн хүлээлгэн өгч, захиалагч байгууллага хүлээн зөвшөөрсний дараа гэрээг дүгнэж санхүүжилтийг олгоно.

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР